



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/НН

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Өрхийн эрүүл мэндийн төвийн даргатай 2017, 2018, 2019, 2020 онд гурвалсан гэрээ байгуулан, гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Бор-Өндөр сумын Засаг дарга /П.Чинбат/-г томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсонтой холбогдуулан хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн ажил үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Бор-Өндөр сумын Засаг дарга /П.Чинбат/-д үүрэг болгосугай.

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 893